



ХӨВСГӨЛ АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА
Л.ТӨМӨРБААТАР ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МОНГОЛ
АРДЫН НАМЫН ХОРООНЫ ДАРГА

АЭДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793. Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.09 № 01/456
таний -ны № -т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн Аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймгийн 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайландаа тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хороонд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны A/49 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хороо нь ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй байна.

Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хорооноос ирүүлсэн хандивын тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.СААД

А.ЭРДЭНЭБААТАР

6724050325

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга Тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 01/цэдэгдугаартай албан бичгийн нэгдүгээр хавсралт

Maggie No. 1

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУЛЬД ОРОЛЦХ НАМ, ЭВСЭЛ, БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИД "ИРГЭН"-ЭЭС ЕГСӨН ХАНДИВЫН ТАЙЛАНГИЙН МАЯГ

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудиторын 2024 оны 07 дугаар сарын 08-ны
өдрийн 01/08-дугаартай албан бичгийн хөөрдүгээр
хавсралт

Маяг №2
**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэлд "Хуулийн ЭТГЭЭД"-ээс өгсөн хандивын тайлангийн
намын хороо
маягт**

Нам, эвслийн нэр: Хөвсгөл аймгийн Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хороо

ДД	Хуулийн этгээдийн нэр	Хандивын жээрийн мэдээлэл	Хандивын тайлангийн намын хороо			АИСДИЛХ-н сонгуулжин тухай хуулийн 53.4-т зассан хандивын мэдээллийн швардрлага хангагч хандивыг буцаан шилжүүлсэн зэсж	Тайлбар
			Хандивын хүлээн авсан шалтгаалалтад төслийн хувь	Хуулийн этгээдийн хэлбэр	Хандивын хүлээн авсан шалтгаалалтад төслийн хувь		
1	Хуулийн этгээдийн нэр	Хандивын жээрийн мэдээлэл	Хайг, утасны дугаар	Үүсгэн бэлжүүлжсан онкою	Үйл ажиллагааны чиглэл	Монгөн дун	Хандивын бушасан дансны дугаар
2	Регистрийн дугаар					Тийм, мөнгөн дун	
...	Дүн						
1	Дүн						
2	Дүн						
...	Нийт дун						

-00000-